

Архивын ерөнхий газрын даргын
2023 оны 22 дугаар сарын 21-ны өдрийн
1962 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН АРХИВ, МЭДЭЭЛЛИЙН САНГААС
ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ

1. Уншлагын танхимаар ашиглуулах үйлчилгээ

д/д	Үйлчилгээний төрөл	Хэмжих нэгж	Үйлчилгээний хөлс /төг/
1	2	3	4
1	Цаасан сууртай эх баримтаар үйлчлэх	1 хадгаламжийн нэгж /1 салбарын 1 жилийн 1 төрлийн баримт/	5,000
2	Цахим сууртай баримтаар үйлчлэх	1 цаг /цахим баримтын санд хандах эрх/	10,000

2. Архивын баримтаас хуулбар олгох үйлчилгээ

д/д	Үйлчилгээний төрөл	Хэмжих нэгж	Үйлчилгээний хөлс /төг/
1	2	3	4
1	Цаасан сууртай эх баримтаас хувилах	A-4 (нэг тал) A-3 (нэг тал)	500 1,000
2	Цахим сууртай баримтаас хувилах	1 зурган файл	500

3. Тоон мэдээллийн сангаас мэдээлэл авах үйлчилгээ

д/д	Үйлчилгээний төрөл	Хэмжих нэгж	Үйлчилгээний хөлс /төг/
1	2	3	4
1	Эх мэдээ /ажиглалтын хугацаагаар/	Нэг салбар Нэг элемент	100
2	Хоногийн дүн, дундаж	Нэг салбар Нэг элемент	200
3	Арав хоног, сарын дүн, дундаж	Нэг салбар Нэг элемент	500
4	Жилийн дүн, дундаж	Нэг салбар Нэг элемент	2,000
5	Цаг агаарын тодорхойлолт, лавлагаа	Нэг тодорхойлолт	20,000



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2023 оны 09 сарын 04-ны
өдрийн 6390 дугаарт бүртгэв.

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 24 өдөр

Дугаар А/68

Улаанбаатар хот

"Төрийн архиваас үзүүлэх үйлчилгээний
хөлсний хэмжээ"-г шинэчлэн тогтоох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1."Төрийн архиваас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ"-г нэгдүгээр хавсралтаар, "Геологийн баримтын төв архиваас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ"-г хоёрдугаар хавсралтаар, "Цаг уур, орчны шинжилгээний газрын архив, мэдээллийн сангаас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ"-г гуравдугаар хавсралтаар, "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн баримтын архиваас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ"-г дөрөвдүгээр хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Энэ тушаалыг зохих бүрдлийн хамт Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, төрийн архивын үйл ажиллагаанд мөрдүүлэх арга хэмжээ авахыг Мэргэжил, арга зүйн удирдлагын газар (Б.Цэндсүрэн)-т даалгасугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Архивын ерөнхий газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/24 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

С.ЭНХБААТАР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

Архивчдын гудамж 1206, Буянт-Ухаа 2,
21 дүгээр хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17121

Утас/Факс: (976) 7700 2098,

Цахим шуудан: info@archives.gov.mn

Цахим хуудас: www.archives.gov.mn

2023.09.06 № 01/517
танай _____-ны № _____-т

「 Архиваас үзүүлэх үйлчилгээний хөлсийг
дагаж мөрдөж ажиллах тухай

Архивын ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн А/68 дугаар тушаалаар "Төрийн архиваас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ"-г шинэчлэн баталж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн болно.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэгт заасныг үндэслэн дээрх тушаалыг 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллана уу.

Жич: "Төрийн архиваас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ"-г шинэчлэн тогтоох тухай А/68 дугаар тушаалыг <http://www.archives.gov.mn/> цахим хуудсанд байршуулсан болно.

ДАРГА



С.ЭНХБААТАР

Монгол
мөрдөж ажиллах
Монгол

1723090845

127